



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/47

Аргатай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны 3.2.1, 3.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дагуу малжуулах төслийн санхүүжилтээр мал нийлүүлэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд: Хүнс, хоршоо, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн  
Амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга  
1 дүгээр багийн засаг дарга  
3 дугаар багийн засаг дарга

2. Мал нийлүүлэх малчин өрхөөс төсөл хөтөлбөрт хамрагдах иргэнд нийлүүлэх малыг аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс ирүүлсэн зах зээлийн үнийг баримталж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд мал нийлүүлэх малчин өрх, төсөл хөтөлбөрт хамрагдаж буй иргэдэд мал худалдах, худалдан авах гэрээг байгуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн, гүйцэтгэсэн ажлын тайланг хугацаанд нь Хөдөлмөрийн хэлтэст тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЗОЛЗАЯА

